

**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2016 оны 08 сарын 22 өдөр

Дугаар 782


Дорноговь аймаг, Сайншанд сум

Хоолны зардал гаргах
тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, “Хүнсний болон эдийн хангалт хийх” журам /код-804/-ын 804.4, “Байгууллагын даргын тушаал гаргах” журам /код-136/-ын 136.4.2-ын “е” дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус аймгийн Мандах суманд 2016 оны 08 дугаар сарын 22-ны өдөр гарсан 201610000259 дугаартай гэмт хэргийн сэжигтэн нарыг баривчлах, байгаа газрыг бүслэн хаах ажиллагаа болон хамгаалалтын постонд 4 хоног 24 цагаар үүрэг гүйцэтгэж ажилласан Цагдаагийн ерөнхий газрын Тусгай ажиллагааны газар, Говьсүмбэр аймаг дахь Цагдаагийн хэлтэс, тус Цагдаагийн газрын нийт 75 алба хаагчдын хоолны зардалд 1.500.000 төгрөг /Нэг сая таван зуун мянга/-ийг зарцуулсугай.

2. Алба хаагчдын хоолонд зарцуулах 1.500.000 төгрөг /Нэг сая таван зуун мянга/-ийг хоолны зардлаас гаргаж, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтыг бүрдүүлж зарцуулахыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн ахмад Б.Лхамсүрэн/-нд зөвшөөрсүгэй.

ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА  С.БААСАНЖАВ